



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



Нэгдсэн Үндэстний
Боловсрол, Шинжлэх Ухаан,
Соёлын Байгууллага

ЮНЕСКО-ийн
Монголын үндэсний
комисс



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
БОЛОВСРОЛЫН САН (FEE)-ИЙН
ГИШҮҮН

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН
ТӨВ НҮТББ



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ



ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ



НАСАН ТҮРШИЙН
БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ



БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВ



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН
НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨХ
ХАМТЫН САНААЧИЛГА, ТҮНШЛЭЛ

НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

Нэгдсэн арга хэмжээ

2021.05.06

Илтгэгч

У.Буяндэлгэр
БОЛОВСРУУЛСАН:

Б.Лхамцэрэн

Д.Энхбаяр

Б.Баярцэцэг

Б.Гэрэлмаа

Ц.Лхагвасүрэн

Д.Түвшинжаргал

М.Хүрэлтогоо

Залуучуудад боломж, эрх мэдэл
олгох

Empowering and mobilizing youth

(ЮНЕСКО, "ТХБ-2030")




АГУУЛГА

- 01** БОДЛОГО, ЧИГЛЭЛД
ТУСГАГДСАН БАЙДАЛ
- 02** ТУРШЛАГА, СУРГАМЖ
- 03** САНАЛ САНААЧИЛГА
- 04** ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ
ОРОЛЦУУЛАХ АРГА
МЕХАНИЗМ
- 05** ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА, ТҮНШЛЭЛ

МУ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨХ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

ТХБ-ын үндэсний хөтөлбөр-зорилт, холбогдох заалтууд



Зорилт-1

Боловсролын салбарын сургалт, судалгааны байгууллагын хүний нөөцийг ТХБ-ын чиглэлээр бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхижуулах

Байгууллагуудад Байгаль орчны менежментийн тогтолцоо MNS болон ISO 14000 багц стандартыг нэвтрүүлэх, дэмжлэг үзүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэх

Зорилт-2



Зорилт-3

Тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэгт хувь нэмэр оруулах залуучуудын манлайлал, идэвхи оролцоо, санаачилгыг хөхиүлэн дэмжих

Салбар бүрт ТХБ-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж, ажилтныг ажиллуулах, ТХБ-ыг эзэмшүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах

Зорилт-4



ТУРШЛАГА, СУРГАМЖ

ТУРШЛАГА

Үндэсний түвшинд:

- Өсвөрийн байгаль хамгаалагчид “Ногоон паспорт” аян зохион байгуулж, гишүүнлэлийг тэлсэн
- **Бидэнд байгаа боломжууд** (Ногоон хөгжлийг дэмжсэн ОУ-ын тэтгэлэгт хөтөлбөр, ТХБ олгох сургалт, клуб гэх мэт олон талын сайн дурын ажилд хамрагдах боломжтой) (Youth club, Movers гэх мэт, линкүүдийг чатаас авах)

Орон нутгийн түвшинд:

- **Ногоон хөгжил дэх бидний оролцоо (“Хоолоо дуусга”** аян явуулсан, энэ нь зохистой хэрэглээнд чиглүүлсэн)
Санаанаас ногоон шийдэл рүү (Хог хаягдлыг ангилах, ялгах менежментийн санаа, зураглал гаргасан)
- Манлайлагч хөвгүүд чуулган зохион байгуулав. Чуулганд 315 хөвгүүд оролцсон.
- Ховд аймгийн залуучуудын хөгжлийн дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Байгууллагын түвшинд:

- ТХБ-ыг нэгж хичээлийн сургалтын хөтөлбөрт интеграцчилах арга зүй, ТХБ-ыг интеграцчилсан 45 нэгж хичээлийн жишээг боловсруулсан.
- 43 сургууль “Эко сургууль” болсон.
- Хүүхдүүд өөрсдөө асуудлыг олж харах, өөрсдөө шийдвэр гаргаж үйл ажиллагааг зохион байгуулж, сургуулийн удирдлага багш нартай хамтран ажиллах эрх мэдэл, боломжийг олгож байгаа
- Өсвөр залуу үеийнхний дунд уралдаан зарлаж урамшуулах
- Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тодорхой хэмжээгээр ТХБ-ыг шингээх туршлага ХААИС-ийн жишээн дээр

СУРГАМЖ

Үндэсний түвшинд:

- Салбар бүр тус тусдаа хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч хамтран ажиллах тал дээр хангалтгүй байна.
- Хаягдалгүй эдийн засгийн загварыг олон улс оронд хэрэгжүүлж байна. Энэ туршлагыг эх орондоо залуучууд хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Бодлогын баримт бичигт тусгагдсан агуулгын хэрэгжилт хангалтгүй байна.
- Хүн бүрийн заавал эзэмших **тогтвортой хөгжлийн зорилтын төлөөх боловсрол (ТХЗБ)** хэмээх цоо шинэ судлагдахуун бүрэлдэж байна.
- ТХБ-ыг байгууллага бүрдээ хэрэгжүүлэх ингэхдээ залуучуудын оролцоо, санаачилгад тулгуурлах.
- Байгаль эх дэлхийтэй харилцах монгол уламжлалт, ёс заншлыг өвлүүлэх, хөгжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн түвшинд:

- Сурагчид ТХБ-ыг интеграцчилсан сургалтад оролцсоноор байгаль орчин, нийгэм, эдийн засгийн уялдаа холбоонд нь шинжлэн судлах, тооцоолох, харьцуулах аргуудыг ашиглан судалснаар, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, чадвар, үнэ зүйлс, хандлагаараа хүчирхэгжин нийгэмд дуу хоолойгоо өргөх боломжтой болж байна.
- Тогтвортой хөгжлийн төлөөх хандлага хангалтгүй байгаа нь цогц чадамжийг эзэмшүүлж чадахгүйд хүргэж байна.

Байгууллагын түвшинд:

- Инженер эдийн засгийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын агуулгыг шингээх туршлага хязгаарлагдмал байгаа нь ирээдүйд ТХ-ийн мэдлэг, чадвар мэдэрэмжгүй мэргэжилтнүүд бэлтгэн гаргах эрсдэл байгаад байна.
- Хичээл сургалтыг танхимаас гадуурх орчинд зохион байгуулах нь хязгаарлагдмал байгаа нь ТХБ-ыг хүүхэд залуучуудад олгох боломжийг бууруулж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЛ


САНАА, САНААЧИЛГА

Хүүхэд залуусын үүрэг хариуцлага

Зохих мэдээллээр хангах
Нийгмийн бүх үйл хэрэгт ялангуяа
ТХБ-д тэргүүлэх оролцоотой байх
Нийгэмд санаачлага оролцоотой байх
Хүүхэд өөрийн зан үйл дадал хэвшлээ
үнэлж, өөрийгөө өөрчлөх, хөгжүүлэхэд
тулгамдаж байгаа асуудлаа илрүүлэх,
хэлэлцэх, туршиж үзэх,

Сайн дурын үйл ажиллагаа ба хүүхэд, залуучууд

Ногоон хөгжил дэх бидний оролцоо
Залуус бие биендээ туслах сайн
дурын хөдөлгөөнийг өрнүүлэх
Хүүхдийн оролцоо, санаачлагуудыг
илрүүлэн дэмжих үйл ажиллагааг
эрчимжүүлэх



Олон улсын түвшинд

НҮБ-ын залуучуудын зөвлөх хорооноос
санаа санаачилгыг дэмжих, ЮНЕСКО-ийн
загвар хурал зохион байгуулах

Залуучуудын платформ үүсгээд ажиллах

Багш, сурган хүмүүжүүлэгч, сургалтын
байгууллага, сурагчдыг холбосон дэлхий
нийтийн платформ бий болгох

Орон нутгийн түвшинд

Орон нутгаараа ТХБ-д суралцах, түүн
дотроо хүүхдийн хөгжлийг дэмжсэн
сургалтын байгууллага болон орон
нутаг хоорондын хамтын ажиллагааг
идэвхжүүлэн ажиллах

Орон нутгийн тулгамдсан асуудлаар
нөлөөллийн ажлууд тогтмол хийх
/Хүүхдээр дамжуулан иргэд, олон
хийдэд нөлөөлөх/

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ОРОЛЦУУЛАХ АРГА МЕХАНИЗМ

Соёлын өвөөр дамжуулан тогтвортой
хөгжлийн төлөөх боловсролыг дэмжих
боломжийг бүрдүүлэх

Хүн бүрийн тасралтгүй суралцах,
тогтвортой ажиллаж, амьдрахад
шаардагдах үйлийн орчныг цогцоор
нь хувирган өөрчлөх чиглэлээр бүх
түвшинд олон талт хамтын
ажиллагаа, түншлэлийн шинэ арга,
механизмыг бүтээх

Олон улсад тухайлбал, ногоон карт
иргэддээ олгож байна. Уг картаар оноо
цуглуулдаг ба BMW гэрчилгээтэй хүн
олны өмнө нэр хүндтэй болж байна.
Байгальд ээлтэй хандлагыг нь
урамшуулах.

Цахим орчинд залуучууд дуу
хоолойгоо хүргэх, (10 гаруй
аргачлал боловсруулан
нэвтрүүлж байна.)

ТХБ хэрэгжүүлэх нь зөвхөн сургууль
багшийн үүрэг бус олон нийт эцэг эхийг
оролцуулах тэдний санаачлагыг дэмжих



ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ОРОЛЦУУЛАХ АРГА МЕХАНИЗМ

Хаягдалгүй эдийн засаг буюу ногоон технологи нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, дэмжих.

Тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээг дэмжих, урамшуулах хөшүүрэг хэрэгжүүлэх.

Сурагч нэг бүрийн оролцоог хангаж, сурагчид хийнгээ, ажиллангаа, судлангаа, туршингаа, хамтран ажиллах явцдаа суралцах, суралцахуйн шинэлэг орчинг бүрдүүлэх талаар бүх түвшинд хамтарч ажиллах

Хүүхдүүдээ "Хүний сэтгэлийн хязгааргүй хүсэл шуналыг хянаж сурах" арга барилыг эзэмшүүлэх

Зөв дадал хэвшилтэй болохын тулд шинийг санаачлах, бусдаас суралцах, өөрийн дотоод мөн чанар луу чиглэхэд хөтөлсөн арга зүйг туршиж хэрэгжүүлэх

Сурагч нэг бүрийн оролцоог хангаж, сурагчид хийнгээ, ажиллангаа, судлангаа, туршингаа, хамтран ажиллах явцдаа суралцах, суралцахуйн шинэлэг орчинг бүрдүүлэх талаар бүх түвшинд хамтарч ажиллах





Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЛ

ДҮГНЭЛТ

1. Хүүхэд залуучуудын дуу хоолойгоор дамжуулан олон нийтэд ТХ, ТХБ-ын үзэл санааг сурталчлан таниулж нөлөөлөх
2. Үндэсний болон орон нутгийн, байгууллагын түвшинд ТХ, ТХЗ, ТХБ-ын төлөөх хүүхэд залуучуудын түншлэл, хамтын ажиллагааг системтэйгээр бэхжүүлэх боломжийг бүрдүүлэх
3. Боловсрол, сургалтын байгууллагууд нь сургалтын орчин, нөхцөл, үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн үзэл санаа, үзэл баримтлалтай уялдуулах, интеграцчилах арга зүйг хэрэгжүүлэх.
4. Монголын уламжлалт ёс заншил, үнэт зүйлсэд тулгуурлан сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг ТХ, ТХБ, ТХЗ-ын үзэл санаатай интеграцичлан сайжруулах, хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна.
5. Хүүхэд залуучуудын дуу хоолойг сонсох, тэдэнд манлайлах санаачлах боломж, эрх мэдлийг олгох, дэмжих шаардлагатай байна.
6. ТХ, ТХБ-ыг бүх чиглэлээр, бүхий л түвшинд хэрхэн интеграцчилах, цогц чадамжийг хэрхэн эзэмшүүлэх, насан туршдаа суралцах боломжийг хэрхэн бүрдүүлэх, бодлогын болон хэрэгжүүлэх түвшний баримт бичиг, төлөвлөгөө, үйл ажиллагаанд тусгагдсан зүйлсээ ямар арга хэлбэрээр ажил хэрэг болгох тал дээр анхааран ажиллах шаардлагатай байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ
ХАМТЫН САНААЧИЛАГА ТҮНШЭЭЛ


7. ХБ-ыг хүүхэд, залуучуудад олгохын тулд насан туршийн боловсролын байгууллагатай хамтран залуучууд руу чиглэсэн үйл ажиллагааг орон нутгийн дүүргийн нэгжтэй хамтран зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Нэг ёсондоо тухайн байгууллагын үйл ажиллагааг ТХБ-ын мэдлэг, чадвар, хандлагыг бий болгоход чиглүүлэн ажиллах нь чухал юм.

8. Хүүхэд, залуучуудад эрх мэдлийг олгох, бие даасан үйл ажиллагааг бий болгох үйл ажиллагааны механизм үндэсний түвшинд ч тэр, орон нутаг, нэгжийн түвшинд ч ялгаагүй сул түвшинд байна. Зөвхөн сургалтын байгууллагын хүрээнд эрх мэдлийн хүрээнд биш макро, микро түвшинд тухайн үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгцээ байна.



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

ЗӨВЛӨМЖ





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨГ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

Анхааран сонссонд баярлалаа

